



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Ус, уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/102/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2022 оны 02 дугаар сар</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас:70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 80112188 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p>
-----------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
4. Аудитын илрүүлэлт .....	14
4.1 Залруулсан алдаа .....	14
4.3 Зөвлөмж.....	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн стандарт
УЦУОШТ	Ус, цаг уур орчны шинжилгээний төв



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,  
Баянхонгор сум, Номгон баг  
Утас, факс 7044 2584

E-mail; bayankhongor@audit.gov.mn

2022.02.16 № 2/06

Г БАЯНХОНГОР АЙМГИЙН УС, ЦАГ  
УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ  
ТӨВИЙН ДАРГА Ч.ОЮУНЧИМЭГ  
ТАНАА

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

D:\2022 он пагмаа\гэрчилгээ\A4-toot.docx

00500186

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>267,702,168.40</b>	<b>250,862,209.27</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	267,702,168.40	250,862,209.27
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	236,586,356.45	222,124,559.32
35110	Тусгай зориулалттай материал	236,586,356.45	222,124,559.32
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	31,115,811.95	28,737,649.95
35410	Бичиг хэргийн материал	481,336.41	426,336.41
35420	Аж ахуйн материал	22,584,246.06	21,424,684.06
35440	Түлш, шатах тослох материал	463,200.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	7,587,029.48	6,886,629.48
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>786,491,068.46</b>	<b>897,309,319.99</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	786,491,068.46	897,309,319.99
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	560,349,068.46	670,892,319.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	522,894,788.20	639,997,043.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,658,073.94	-43,793,525.10
39203	Авто-тээврийн хэрэгсэл	78,608,973.78	78,608,973.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	-31,719,328.96	-41,097,257.92
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	341,976,540.52	270,176,971.52
39206	Хуримтлагдсан элэгдэл	-322,691,720.41	-240,579,664.61
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	26,169,716.00	15,507,750.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-22,350,993.46	-7,927,970.96
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,280,000.00	6,280,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,160,833.27	-6,280,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	226,142,000.00	226,417,000.00
39301	Программ хангамж	1,562,719.00	1,546,219.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,562,719.00	-1,271,219.00
39303	Бусад биет бус хөрөнгө	226,142,000.00	226,142,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,054,193,236.86</b>	<b>1,148,171,529.26</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	00.00	507,176.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	209,576.00
413103	ХАОАТ өглөг		209,576.00
413101	Цалингийн өглөг		297,600.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,054,193,236.86</b>	<b>1,147,664,353.26</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,054,193,236.86	1,147,664,353.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	587,740,743.91	587,740,743.91
51101	Өмч: - төрийн	587,740,743.91	587,740,743.91
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	113,515,324.98	221,921,656.88
51210	Өмнөх үеийн үр дүн	113,515,324.98	128,450,540.48
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	93,471,116.40
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,937,167.97	338,001,952.47
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,054,193,236.86</b>	<b>1,148,171,529.26</b>



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,564,345,674.55</b>	<b>1,469,181,339.37</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>144,317,619.55</b>	<b>159,731,322.37</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>144,317,619.55</b>	<b>159,731,322.37</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	144,317,619.55	159,731,322.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	144,117,619.55	159,531,322.37
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,420,028,055.00</b>	<b>1,309,450,017.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,383,209,200.00</b>	<b>1,261,539,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,383,209,200.00	1,261,539,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,010,782.00</b>	<b>47,828,313.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,782.00	26,736,313.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,910,000.00	21,092,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,808,073.00</b>	<b>82,004.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,808,073.00	82,004.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,495,798,499.74</b>	<b>1,375,681,856.58</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,495,798,499.74</b>	<b>1,375,681,856.58</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,336,440,361.74</b>	<b>1,335,132,521.58</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,039,835,310.00</b>	<b>1,040,256,978.00</b>
210101	Үндсэн цалин	729,445,224.00	731,799,420.00
210102	Нэмэгдэл	280,202,986.00	279,346,996.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	29,110,562.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>140,377,700.00</b>	<b>140,204,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	98,784,300.00	98,784,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,398,300.00	10,398,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,665,300.00	8,318,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,733,100.00	1,906,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,796,700.00	20,796,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,258,914.00</b>	<b>25,822,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,579,014.00	4,180,400.00
210302	Түлш, халаалт	20,415,900.00	21,641,600.00
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>32,344,647.70</b>	<b>31,210,420.53</b>
210401	Бичиг хэрэг	1,310,740.00	1,286,300.00
210402	Тээвэр, шатахуун	15,574,700.00	14,230,663.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,768,932.00	1,471,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	635,000.00	4,673,323.85
210408	Бараа материал акталсны зардал	12,055,275.70	9,548,903.68
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>464,500.00</b>	<b>244,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	244,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>42,073,700.34</b>	<b>47,942,254.95</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,314,600.34	45,301,254.95
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	33,100.00	00.00
210604	Урсгал засвар	1,726,000.00	2,641,000.00
<b>2107</b>	<b>Томиллот, зочны зардал</b>	<b>2,981,000.00</b>	<b>2,577,000.00</b>
210702	Дотоод албан томиллот	2,981,000.00	2,577,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,364,140.00</b>	<b>15,979,352.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,559,740.00	14,407,829.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	275,000.00	277,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,518.00	401,992.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	24,700.00	24,700.00
210807	Газрын төлбөр	1,068,382.00	752,831.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,740,449.70</b>	<b>30,895,516.10</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	358,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	30,740,449.70	30,536,716.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>159,358,138.00</b>	<b>40,549,335.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>157,654,230.00</b>	<b>40,226,404.00</b>

**Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,808,073.00	82,004.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,846,157.00	40,144,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,703,908.00</b>	<b>322,931.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,703,908.00	322,931.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>68,547,174.81</b>	<b>93,499,482.79</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>28,366.39</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	28,366.39
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>00.00</b>	<b>-28,366.39</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>68,547,174.81</b>	<b>93,471,116.40</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,776,628.17	985,646,062.05
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	191,522.00	191,522.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.91	353,128,689.97	44,968,150.17	985,837,584.05
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	68,547,174.81	68,547,174.81
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	352,937,167.97	113,515,324.98	1,054,193,236.86
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	352,937,167.97	113,515,324.98	1,054,193,236.86
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	14,935,215.50	14,935,215.50
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	587,740,743.91	352,937,167.97	128,450,540.48	1,069,128,452.36
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-14,935,215.50	00.00	-14,935,215.50
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	93,471,092.40	93,471,092.40
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	587,740,743.91	338,001,952.47	221,921,632.88	1,147,664,329.26

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,421,031,974.00</b>	<b>1,309,650,017.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,003,919.00</b>	<b>200,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,003,919.00</b>	<b>200,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,003,919.00	200,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,003,919.00	200,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,420,028,055.00</b>	<b>1,309,450,017.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,383,209,200.00</b>	<b>1,261,539,700.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,383,209,200.00	1,261,539,700.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,010,782.00</b>	<b>47,828,313.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,782.00	26,736,313.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,910,000.00	21,092,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,808,073.00</b>	<b>82,004.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	1,808,073.00	82,004.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,419,981,974.00</b>	<b>1,286,871,182.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,419,981,974.00</b>	<b>1,286,871,182.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,260,623,836.00</b>	<b>1,246,321,847.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,039,835,310.00</b>	<b>1,039,749,802.00</b>
210101	Үндсэн цалин	735,084,110.00	730,451,391.00



**Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210102	Нэмэгдэл	274,564,100.00	279,131,849.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,166,562.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>140,377,700.00</b>	<b>140,204,500.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	98,784,300.00	98,784,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	10,398,300.00	10,398,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,318,700.00	8,318,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,079,700.00	1,906,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	20,796,700.00	20,796,700.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,419,300.00</b>	<b>22,578,400.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,523,500.00	4,180,400.00
210302	Түлш, халаалт	20,631,800.00	18,398,000.00
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,770,440.00</b>	<b>5,536,851.00</b>
210401	Бичиг хэрэг	763,140.00	754,881.00
210402	Тээвэр, шатахуун	4,274,700.00	3,088,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,424,800.00	1,297,270.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	307,800.00	396,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>464,500.00</b>	<b>464,500.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	464,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>568,800.00</b>	<b>560,290.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	508,500.00	499,990.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,300.00	60,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,981,000.00</b>	<b>2,577,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,981,000.00	2,577,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>43,206,786.00</b>	<b>34,291,704.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,402,386.00	32,720,181.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	275,000.00	277,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	321,518.00	401,992.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,700.00	24,700.00
210807	Газрын төлбөр	1,068,382.00	752,831.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>358,800.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	358,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>159,358,138.00</b>	<b>40,549,335.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>157,654,230.00</b>	<b>40,226,404.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	1,808,073.00	82,004.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	155,846,157.00	40,144,400.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>1,703,908.00</b>	<b>322,931.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,703,908.00	322,931.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>1,050,000.00</b>	<b>22,778,835.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,050,000.00</b>	<b>22,778,835.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,050,000.00</b>	<b>22,778,835.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,050,000.00</b>	<b>22,778,835.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,050,000.00	22,778,835.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-1,050,000.00</b>	<b>-22,778,835.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,261,739,700.00	1,261,452,485.00	287,215.00	100%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,261,739,700.00	1,261,452,485.00	287,215.00	100%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,221,595,300.00	1,221,308,085.00	287,215.00	100%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,039,835,400.00	1,039,749,802.00	85,598.00	100%
210101	Үндсэн цалин	730,487,400.00	730,451,391.00	36,009.00	100%
210102	Нэмэгдэл	279,160,900.00	279,131,849.00	29,051.00	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,187,100.00	30,166,562.00	20,538.00	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	140,377,900.00	140,204,500.00	173,400.00	100%
210201	Тэтгэврийн даатгал	98,784,400.00	98,784,400.00	0.00	100%
210202	Тэтгэмжийн даатгал	10,398,400.00	10,398,400.00	0.00	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,318,700.00	8,318,700.00	0.00	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	2,079,700.00	1,906,300.00	173,400.00	92%
210205	Эрүүл мэндийн даатгал	20,796,700.00	20,796,700.00	0.00	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,585,800.00	22,578,400.00	7,400.00	100%
210301	Гэрэл, цахилгаан	4,180,400.00	4,180,400.00	0.00	100%
210302	Түлш, халаалт	18,405,400.00	18,398,000.00	7,400.00	100%
2104	Хангамж, бараа материалын зардал	5,539,500.00	5,536,851.00	2,649.00	100%
210401	Бичиг хэрэг	755,000.00	754,881.00	119.00	100%
210402	Тээвэр, шатахуун	3,088,500.00	3,088,500.00	0.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,298,100.00	1,297,270.00	830.00	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	397,900.00	396,200.00	1,700.00	100%
2105	Нормативт зардал	464,500.00	464,500.00	0.00	100%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	464,500.00	464,500.00	0.00	100%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	560,300.00	560,290.00	10.00	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	499,990.00	10.00	100%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	60,300.00	60,300.00	0.00	100%
2107	Томилот, зочны зардал	2,583,500.00	2,577,000.00	6,500.00	100%
210702	Дотоод албан томилот	2,583,500.00	2,577,000.00	6,500.00	100%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,289,600.00	9,277,942.00	11,658.00	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,706,600.00	7,706,419.00	181.00	100%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	277,200.00	277,200.00	0.00	100%
210803	Даатгалын үйлчилгээ	402,000.00	401,992.00	8.00	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	114,800.00	114,800.00	0.00	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	24,700.00	24,700.00	0.00	100%
210807	Газрын төлбөр	764,300.00	752,831.00	11,469.00	98%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	358,800.00	358,800.00	0.00	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	358,800.00	358,800.00	0.00	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	401,444,000.00	401,444,000.00	0.00	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,144,400.00	40,144,400.00	0.00	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	40,144,400.00	40,144,400.00	0.00	100%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,261,739,700.00</b>	<b>1,261,452,485.00</b>	<b>287,215.00</b>	<b>100%</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,261,539,700.00	1,261,252,485.00	287,215.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,261,539,700.00	1,261,252,485.00	287,215.00	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	200,000.00	200,000.00	0.00	100%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	200,000.00	200,000.00	0.00	100%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	90.00	90.00	0.00	100%
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	0.00	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	83.00	83.00	0.00	100%

620003	Үйлчлэх ажилтан	06.00	06.00	0.00	100%
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>90.00</b>	<b>90.00</b>	<b>0.00</b>	<b>100%</b>
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	90.00	90.00	0.00	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,006,784.00	47,792,597.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>35,006,784.00</b>	<b>47,792,597.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,100,782.00	26,736,313.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	22,906,002.00	21,056,284.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бэлтгэн нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулахдаа бараа материалын үнийг тодорхой тусгах, онцгой комиссоос олгож байгаа зардлын анхан шатны баримтын бүрдэлд хяналт тавих, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын даргын шийдвэрийг бүрэн байршуулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер А.Цээням, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр ирүүлсэн ба тайланд жил хөрөнгө зарцуулахад нэг дүгээр гарын үсгийн дарга Ч.Оюунчимэг, хоёр дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Энхжаргал нар зурсан байна.



### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянхонгор аймгийн УЦУОШТ нь Ус, цаг уур, орчны бодит болон ирээдүйн төлөв байдлын тухай мэдээллээр төр засаг, аж ахуйн салбар нэгж, байгууллага, нийт ард иргэдийн эрэлт хэрэгцээг хангах, хяналт шинжилгээний мэдээ баримтын шуурхай болон горимын боловсруулалт хийх, байгаль орчны мэдээллийн төв сангийн уур амьсгал, гадаргын усны мэдээллийн дэд санг бүрдүүлэх. Орон нутгийн цаг уур, хөдөө аж ахуйн цаг уур, агаарын дээд давхарга судлал, нарны цацраг судлал, орчны шинжилгээ, гадаргын усны хяналт шинжилгээний улсын сүлжээг арга зүйн удирдлагаар хангах зэрэг зорилтыг дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Цаг уур орчны шинжилгээний газрын дотоод аудитын нэгж дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж аваагүй, аудитад ашиглах баримт материал байхгүй байсан ба дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,495,798.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 22,426,9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 15,705.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 14,439.3 мянган төгрөг байгаа тул, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянхонгор аймгийн УЦУОШТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,148,171.5 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 93,978.29 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Мян.төг
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	267,702.2	250,862.2	(16,840.0)
Бараа материал	267,702.2	250,862.2	(16,840.0)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	786,491.1	897,309.3	110,818.3
Үндсэн хөрөнгө	1,203,634.7	1,238,259.0	34,624.2
Хуримтлагдсан элэгдэл	(417,143.7)	(340,949.6)	76,194.0
Нийт хөрөнгө	1,054,193.2	1,148,171.5	93,978.3
Өр төлбөр	-	507.2	507.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,054,193.2	1,148,171.5	93,978.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,054,193.2	1,148,171.5	93,978.3

Эх сурвалж: Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлан

Тус байгууллагын төрийн сан банкны харилцах данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 250,862.2 мянган төгрөг болж өмнөх оноос 16,840.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 40,640.7 мянга, ЦУОШТ-өөс үнэ төлбөргүй 40,745.9 мянга, хандиваар 180.9 мянган төгрөгийн бараа материалыг хүлээн авч 88,858.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, байгууллагын даргын өдрийн ...дугаарт тушаалаар 8,117.4 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал, 1,431.5 мянган төгрөгийн аж ахуйн материал акталснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,238,259 мянган төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 34,624.2 мянган төгрөгөөр өссөн нь УТХО-аар баригдсан Баянцагаан сумын Өртөөний барилга 95,352.2 мянга, Богд, Галуут сумын өртөөний барилгад төсвийн хөрөнгөөр 22,778.8 мянган төгрөгийн урсгал засвар хийж барилгын сайжруулалтаар бүртгэсэн, хандив тусламжаар 350.0 мянга, ТӨБЗГ-ын 2021.06.14-ны өдрийн А/192 дугаар тогтоолоор ЦУОШТ-өөс 4,772.9 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн орлого авч, 18,362.9 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, хуримтлагдсан элэгдлээрээ өртгөө нөхсөн 89081.4 мянган төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж дахин ашиглах боломжтой хөрөнгийг 18,529.5 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитаар цалин, НДШ, ХХОАТ-ыг давтан тооцоолоход 507.2 мянган төгрөгийн өглөгийг бүртгэл тайланд тусгаагүй байсныг санхүүгийн тайланд залруулснаар өглөг нэмэгдсэн.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 93,471.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нөөц данснаас 14,971.1 мянган төгрөгөөр буурч 1,148,171.5 мянган болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,886,822.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 300.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,887,122.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 1,266,586.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 4,846.7 мянган төгрөг хасагдан 1,261,739.7 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс 1,261,539.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 200.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,261,539.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, өөрийн орлогоор 1257.0 мянга төгрөг оруулж, урсгал үйл ажиллагаанд 1,261,452.5 мянган төгрөгийг зарцуулж 287.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,261,452.5 мянган төгрөг байгаа нь ажил олгогчоос төлөх цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг 258.9 мянга, газрын төлбөр 11.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ОНХС-аас 20,000.0 мянга, ЦУОШТ-өөс их засварт 22,778.9 мянга, бусад эх үүсвэрээс 5,014.4 мянга нийт 47,828.3 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Аймгийн ОНХС-аас нэмэлт санхүүжилтээр цаг уурт зориудаар нөлөөлөхөд 20,000.0 мянган төгрөг олгосон ба тус үйл ажиллагааны 1 дэх гаралтад аймгийн нутгийн 30-35 хувьд Уулархаг бүсийн нутгаар хур тунадас орсон. 2 дахь гаралтад аймгийн нутгийн 80-98 хувьд хамруулж нийт нутгаар хур тунадас орсон байна. 3-5 дахь гаралтад Богд сумын Их Богд уул, Шинэжинст сумын Эхийн голын нутаг, Баян-Овоо сумын Үүдэд 0.1-1.0 мм бороо, нойтон цас орсон. 6-7 дохь гаралтад Баянхонгор, Галуут, Баянбулаг Шинэжинст, Хориулт, Баацагаан, Гурванбулаг, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Эрдэнэцогтын нутгаар 0.1-5.0 мм бороо орж, нутгийн 50-55 хувийг хамарсан. 8-12 дахь гаралтад аймгийн нийт нутгийг 95-98 хувь хамарч их хэмжээний бороо орсон. Хур тунадасны хэмжээг олон жилийн дундажтай харьцуулахад 3 дугаар сард Баацагаан сумын нутгаар олон жилийн дунджаас 1.0-3.0 миллиметрээр хур тунадас нэмэгдсэн гэж мэдээлсэн байна.



### **3.8 Аудитын гол асуудал**

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2021 онд 4 зорилтын хүрээнд 32 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 98.9 хувьтай гаргасан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Баянхонгор аймгийн УЦУОШТ нь 2021 онд 1,330,462.9 төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн 6.4.5-д заасан 207,441.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, 101,906.7 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 2021 оны 1 болон 11 дүгээр сарын нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

#### **3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт**

Байгууллагын төсвийн хөрөнгийн зарцуулалтад тогтоолын хэрэгжилтийг шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- 2021 оны төсвийг 1,266,586.4 мянган төгрөгөөр баталсан ба тодотголоор 4,846.7 мянган төгрөг хасаж 1,261,739.7 мянган төгрөгийн төсвийг улсын төсвөөс 1,261,539.7 мянган төгрөг, өөрийн орлогоор 200.0 мянган төгрөг санхүүжүүлэхээр тодотгон баталсан.

- Тайланд онд Эхийн гол өртөөний техникч 2021 оны 2-р сард, Богд сумын өртөөний техникч 6-р сард өндөр насны тэтгэвэрт гарсан ба 2 орон тоо нь ажлын шаардлагаар зайлшгүй байх тул байгууллагын даргын 2021 оны Б/10, Б/32 дугаар тушаалаар 2 ажилтан авч ажиллуулжээ.

- Албан томилолтын зардлыг 2,583.5 мянган төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 2,577.0 мянган төгрөг зарцуулж 6.5 мянган төгрөг хэмнэжээ.



- Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 26,090.4 мянган төгрөгөөр, тодотголоор 22,585.8 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 22,578.4 мянган төгрөг зарцуулж анх баталсан дүнгээс 3512.0 мянган төгрөг буюу 13.5 хувь хэмнэсэн. Гэвч 2021 оны 12 дугаар сард түлш, халаалтын зардлын өглөг 2500.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансаар ЦУОШТ-аас авч барагдуулсан нь ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 20 хувь бууруулж хэмнэх дээрх тогтоолын 1.8 дах заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### **3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь 2021 онд төсвийн хөрөнгөөр сумдад нийлүүлэгдэх 19,471.8 мянган төгрөгийн мод нүүрс бэлтгэх, ЦУОШТ-өөс нэмэлт санхүүжилтээр санхүүжих Галуут сумын өртөөний барилын дулааны шугамд холбох 13,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй их засвар, Богд сумын өртөөний барилгын 10,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй их засварын ажлыг гүйцэтгүүлэх тендерийг аймгийн ОНӨА-аар зохион байгуулж ТБОНӨХБАҮХАТХ-ыг хэрэгжүүлсэн.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Алтантуяа гүйцэтгэж, нийт 7632.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1652.6 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5980.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж зөвлөмж өгснийг хэрэгжүүлж, хэрэгжилтийг байгууллагын 2021.05.28 өдрийн 85, 2021.10.08-ны өдрийн 141 дугаарт албан бичгээр тус тус ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,713.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 507.2 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, зөрчил арилгах 4,206.1 мянган төгрөгийн зөрчилд зөрчлийг дахин гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг давтан тооцоолоход ажиллагсдын цалингаас суутган тооцсон хуримтлалын 110.0 мянга, ШШГА-т шилжүүлэхээр суутган тооцсон 187.6 мянга, ХХОАТ-ын 209.6 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэн тайланд өглөгөөр тусгаагүй байна

Иймд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалтыг үндэслэн санхүүгийн тайланд залруулав.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд цалингийн өглөг 297.6 мянга, ХХОАТ-ын өглөг 209.6 мянган төгрөг үүсгэн залруулав.

### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

## 1. Илрүүлэлт

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг 26,090.4 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 25078.4 мянган төгрөг ба Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.8<sup>1</sup> дахь заалтаар 5,218.6 мянган төгрөг хэмнэхээс 1012.0 мянган төгрөг хэмнэж тогтоолыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол, журмыг хэрэгжүүлэн ажиллах.

## 2. Илрүүлэлт

Баянхонгор аймгийн УЦУОШТ нь 2021 онд 1,330,462.9 төгрөгийн 89 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хуулийн 6.4.5-д заасан 207,441.9 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй, 101,906.7 мянган төгрөгийн 1 гүйлгээ, 2021 оны 1 болон 11 дүгээр сарын нийт 14 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

### Өгсөн зөвлөмж

Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хуулийн 6.4.5-д заасан мэдээллийг хуулийн хугацаанд тухай бүр байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
				Залруулга				Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Төлбөрийн акт	Албан шаардлага		Зөвлөмж		
1	Баянхонгор аймгийн УЦУОШТ	3	4713.3	1	507.2	0	0	0	0.0	2	4,206.1

---oOo---

<sup>1</sup> байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах

